

ТӨСӨВ САНХҮҮГИЙН 2022 ОНЫ ТАЙЛАН

1. Тус газар 2022 оны 4-р улиралын байдлаар Орон нутгийн төсвөөс 738865.0 мянган төгрөгний санхүүжилт, өөрийн орлогоос 3500.0 мянган төгрөгний санхүүжилтийг бүрдүүлж нийт 742365.0 мянган төгрөгний төсөвтэйгээр үйл ажиллагаагаа явуулав. Аймгийн Засаг даргын захирамжаар 44 хүний орон тоогоор орон тоог баталж удирдах ажилтан 1, мэргэжилтэн 9, байгаль хамгаалагч 21, үйлчилгээний ажилтан 10, гэрээт ажилтан 3 байна. Өөрийн орлогоод төсөвт ус ашиглах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлснөөс 950.0 мянган төгрөг, бусад орлогоос 2550.0 мянган төгрөг оруулж төлөвлөгөөг 100% биелүүлсэн.

2. Нийт төсвийн 404306.9 мянган төгрөгийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулалд төсвийн 54.4%, 46789.7 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх НДШ-д төсвийн 6.3%, 12608.6 мянган төгрөгийг байр ашиглалтай холбоотой тогтмол зардалд төсвийн 1.7%, 4423.0 мянган төгрөгийг хангамж төсвийн 0.6 %, бараа материалын зардалд, 496.0 мянган төгрөгийг нормативт зардалд, 257.2 мянган төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардалд, 1082.7 мянган төгрөгийг дотоод албан томилолтын зардалд, 373.9 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, төлбөр хураамжын зардалд, 239000.0 мянган төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажилд төсвийн 32.3%, 9536.2 төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, 23490.4 мянган төгрөгийг 1 хүний тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд тус тус зарцуулав.

3. Орон нутгийн өмчийн тооллого, санхүүгийн улирал, хагас жил, бүтэн жилийн тайлан, татварын улирал, хагас жил, бүтэн жилийн тайлан, нийгмийн даатгалын сар бүрийн тайлан, байгууллагын шилэн дансны тухай бүрийн, өдөр тутмын мэдээлэлүүдийг хугацаанд үнэн зөв байршуулж тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд гаргаж өгч удирдлагыг мэдээ мэдээллээр бүрэн хангаж ажиллав.